БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Агуулга | Хийх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах нэгж | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах<br>Үндэслэл:<br>• Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээрр зүйлийн 9.1.2. | 1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | Жилийн турш | ЭБАТ | |
| 2. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох<br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 | 2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулах, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах | Жилийн турш | БТГ<br>ХБГХБХЗГ<br>ББМҮБХЗГ<br>НААБХЗГ<br>ИДББХЗГ<br>ХХ | |
| | | 2.2. Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох | Жилийн турш | БТГ<br>ХБГХБХЗГ<br>ББМҮБХЗГ<br>НААБХЗГ<br>ИДББХЗГ | |
| 3. | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | 3.1. Тухайн жилд явуулах дотоод аудитын ажлын оны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | Жилийн турш | ХШҮДАГ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Эрх зүйн үндэслэл:<br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 | 3.2. Дотоод аудитын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлэх | Жилийн турш | ХШҮДАГ | |
| 4. | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудас/<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9. | 4.1. Тухайн жилийн төсөв | 1 дүгээр сар | БТГ Хариуцсан мэргэжилтэн | С.Должинсүрэн |
| | | 4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл | 4 дүгээр сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.3. Сарын төсвийн гүйцэтгэл | Тухай бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл | Тухай бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл | 8 дугаар сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан | 8 дугаар сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.7. Дараа жилийн төсвийн төсөл | 9 дүгээр сар | БТГ Хариуцсан мэргэжилтэн | С.Должинсүрэн |
| | | 4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан | 4 дүгээр сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | 4 дүгээр сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | 6 дугаар сар | ТЗУГ-СХ | |
| | | 4.11. Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбар | улирал бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Тухай бүр | БТГ Хариуцсан мэргэжилтэн | С.Должинсүрэн |
| | | 4.13. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | Тухай бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.14. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Тухай бүр | ТЗУГ Хариуцсан мэргэжилтэн | Б.Цолмон-Эрдэнэ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 4.15. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Тухай бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.16.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт/ тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | ТЗУГ-СХ | |
| | | 4.17.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл | Тухай бүр | БТГ-ХОҮХ | |
| 5. | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | 5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл */тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/*-ийн жагсаалтыг гаргаж цахим хуудсандаа байршуулах | Жилийн турш | ББМҮБХЗГ<br>ХБГХБХЗГ<br>Хариуцсан мэргэжилтэн | Тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга |
| | | 5.2.Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах | Жилийн турш | ББМҮБХЗГ<br>ХБГХБХЗГ<br>Хариуцсан мэргэжилтэн | Тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга |
| | | 5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Жилийн турш | ББМҮБХЗГ<br>ХБГХБХЗГ<br>Хариуцсан мэргэжилтэн | Тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга |
| 6. | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | 6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах, сонгон шалгаруулалт явуулах тухай нийтэд мэдээлэх /тухай бүр шинэчилсэн/ | Жилийн турш | ТЗУГ<br>Хүний нөөц | Б.Цолмон-Эрдэнэ |
| 7. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | 7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | Жилийн турш | БТГ-ХОҮХ | |
| | | 7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх | Тухай бүр | БТГ-ХОҮХ | |
| | | 7.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл | Тухай бүр | БТГ-ХОҮХ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | БТГ-ХОҮХ | |
| | | 7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | БТГ-ХОҮХ | |
| 8. | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох | 8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх | Жилийн турш | ТЗУГ Хүний нөөц | |
| | | 8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох | Жилийн турш | ТЗУГ Хүний нөөц | |
| 9. | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | 9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх */1 ба түүнээс дээш/* | Жилийн турш | ТЗУГ Бодлогын газрууд | |
| | | 9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл | Жилийн турш | ТЗУГ Бодлогын газрууд | |
| 10. | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | 10.1.Ёс зүйн дүрмийг мөрдүүдэх, албан хаагч нарт танилцуулах | Жилийн турш | Ёс зүйн хороо | |
| | | 10.2.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах, зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх | Жилийн турш | Ёс зүйн хороо | |
| | | 10.3.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх | Тухай бүр | Ёс зүйн хороо | |
| | | 10.4.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх | 12-р сар | Ёс зүйн хороо | |
| 11. | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх | 11.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах | Тухай бүр | ТЗУГ Хүний нөөц | |
| | | 11.2.Яамны албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа гаргах, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргах | Тухай бүр | ТЗУГ Хүний нөөц | |
| 12. | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг | 12.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг цахим | Тухай бүр | Мэдээллийн технологи | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хангах | хуудсаараа бүрдүүлэх | | хариуцсан мэргэжилтэн | |
| | | 12.2.Сайдаас гаргасан төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад тушаалыг тухай бүр цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | ТЗУГ-ХХ Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн | |
| | | 12.3.ТНБД-ын гаргасан төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад тушаалыг тухай бүр цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | ТЗУГ-ХХ Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн | |
| | | 12.4.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | ТЗУГ-ХХ Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн | |
| 13. | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | 13.1.Хууль тогтоомжоор тогтоосон Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаараа иргэдэд мэдээлж, сурталчлах | Тухай бүр | ТЗУГ-ХХ Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн | |
| | | 13.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) | Тухай бүр | ТЗУГ Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн | |
| | | 13.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | Тухай бүр | Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | |
| | | 13.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар мэдээлэх | Тухай бүр | Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн | |
| 14. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | 14.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг | Тухай бүр | ТЗУГ ХШҮДАГ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлах | | | |
| | | 14.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/ | Тухай бүр | ТЗУГ ХШҮДАГ | |
| 15. | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | 15.1.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хүлээн авч, биелэлтийг зохион байгуулж ажиллах | Тухай бүр | ЭБАТ | Зөвлөмж чиглэлийг танилцуулж, хэрэгжилтийг зохион байгуулах |
| | | 15.2. АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн мөрөөр холбогдох арга хэмжээ авах, хариу мэдэгдэх | Тухай бүр | ЭБАТ | |
| | | 15.3. АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангах, хугацаанд нь хариу өгөх | Тухай бүр | ЭБАТ | |
| | | 15.4. АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангах, хариу өгөх | Тухай бүр | ЭБАТ | |
| Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга | | | | | |
| 16. | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | 16.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Жилийн турш | ЭБАТ, ТНБД | |
| | | 16.2.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ-т хүргүүлэх | | ЭБАТ | |
| 17. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | 17.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилгад нэгдэх | Жилийн турш | ТЗУГ | |
| | | 17.2.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ | Жилийн турш | ТЗУГ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18. | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | 18.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /сургалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, зөвлөмж/-г авах | Жилийн турш | ТЗУГ<br>Ёс зүйн хорооны нарийн бичиг<br>Сургалт хариуцсан мэргэжилтэн | Шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх |